

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөлөнбуйр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОО-2023/13/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор: Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	10
3.4.2 Авлага.....	11
3.4.3 Бараа материал	Error! Bookmark not defined.
3.4.4 Үндсэн хөрөнгө	Error! Bookmark not defined.
3.4.5 Засгийн газрын хувь оролцоо	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	Error! Bookmark not defined.
3.5.1 Төсвийн төлөвлөлт	Error! Bookmark not defined.
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
3.5.3 Нэмэлт төсөв.....	Error! Bookmark not defined.
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
5.1 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
5.2 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	108

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.03.25 № 333

танай _____-ны № _____-т

ХӨЛӨНБУЙР СУМЫН ЗАСАГ

ДАРГА Д.ТӨРБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөлөнбуйр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөлөнбуйр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн бодитой тооцож төлөвлөөгүй байна.

Аудитын гол асуудал

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/06 дугаар тогтоолоор "хангалттай" гэж дүгнэсэн нь бодитой биш байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

011021221

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	719,239.4	622,273.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	285,951.1	204,686.8
33	АВЛАГА	206,002.1	207,220.1
35	БАРАА МАТЕРИАЛ	227,286.3	210,366.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,484,734.0	4,531,043.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,484,734.0	4,531,043.6
39200	Биет хөрөнгө	4,420,500.9	4,428,026.4
39300	Биет бус хөрөнгө	64,233.2	103,017.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,203,973.4	5,153,317.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,822.8	1,939.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,822.8	1,939.9
41300	Өглөг	1,822.8	1,939.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,202,150.6	5,151,377.5
51	Засгийн газрын хувь оролцоо	5,202,150.6	5,151,377.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	734,596.9	774,129.9
51200	Хуримтлагдсан үр дүн	4,325,084.1	4,234,778.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	142,469.6	142,469.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,203,973.4	5,153,317.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,352,881.6	1,683,213.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	182,118.1	247,322.3
110	Орлогын албан татвар	118,136.5	157,535.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	127,797.0	167,425.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,660.6	-9,890.3
113	Хөрөнгийн албан татвар	40,329.3	77,200.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	23,652.4	12,586.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,697,753.8	511,548.6
120	Нийтлэг татварын бус орлого	1,697,753.8	511,548.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,473,009.7	924,342.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,946,874.5	1,321,533.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,946,874.5	1,321,533.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,225,208.8	1,321,533.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	355,307.4	454,562.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,577.2	55,896.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,968.8	16,511.1
2104	Хангамж, бараа материалын зардал	37,967.0	30,480.6
2105	Нормативт зардал	464.0	1,133.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,512.5	21,927.3

**Хөлөнбуйр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2107	Томилолт, зочны зардал	4,242.0	6,372.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,074.8	271,130.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	528,095.1	463,519.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	721,665.7	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,406,007.1	361,680.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,753,621.0	451,986.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,347,613.9	-90,306.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,601,525.3	0.0	7,601,525.3
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,202,150.6	0.0	5,202,150.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,549,764.5	0.0	7,549,764.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-51,760.9	0.0	-51,760.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	-2,347,613.9	0.0	-2,347,613.9
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,202,150.6	0.0	5,202,150.6
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,151,377.5	0.0	5,151,377.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,202,150.6	0.0	5,202,150.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	39,533.0	0.0	39,533.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-90,306.0	0.0	-90,306.0

Хөлөнбуйр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,916,483.3	1,464,586.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	182,118.1	247,322.3
110	Орлогын албан татвар	118,136.5	157,535.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	127,797.0	167,425.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,660.6	-9,890.3
113	Хөрөнгийн албан татвар	40,329.3	77,200.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	23,652.4	12,586.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,439.5	2,845.4
1181	Газрын төлбөр	22,212.9	9,741.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	261,355.6	292,920.9
120	Нийтлэг татварын бус орлого	261,355.6	292,920.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,473,009.7	924,342.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,535,213.2	1,055,064.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,535,213.2	1,055,064.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	813,547.5	1,055,064.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	387,972.4	483,537.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,267.9	58,982.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150,704.5	88,411.8
2104	Хангамж, бараа материалын зардал	26,403.5	36,442.2
2105	Нормативт зардал	464.0	1,466.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,019.4	21,717.3
2107	Томилолт, зочны зардал	4,242.0	6,372.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,644.9	176,433.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	157,828.8	181,701.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	721,665.7	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	381,270.2	409,521.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	276,514.7	440,785.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	276,514.7	440,785.5
2200	Дотоод эх үүсвэрээр	276,514.7	440,785.5
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-276,514.7	-440,785.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-75,000.0	-50,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	75,000.0	50,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	29,755.5	-81,264.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	256,195.6	285,951.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	285,951.1	204,686.8

Хөлөнбуйр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,375,410.4	1,298,674.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	819,129.7	808,619.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	819,129.7	808,619.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	451,858.7	446,687.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,523.7	55,896.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,232.9	157,770.2
2104	Хангамж, бараа материалын зардал	27,350.0	27,202.1
2105	Нормативт зардал	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,214.3	54,990.9
2107	Томилолт, зочны зардал	6,372.0	6,372.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,916.7	2,834.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,810.6	56,865.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	484,131.5	440,054.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	70,000.0	50,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,375,410.4	1,319,770.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,066,457.5	1,088,451.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	308,952.9	231,318.8
	мөнгө ,түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		79,698.1
	мөнгө ,түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		231,318.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	156,775.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	156,775.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	135,103.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,874.6
2104	Хангамж, бараа материалын зардал	1,822.2
2105	Нормативт зардал	1,466.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,797.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119,143.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,672.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,672.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	156,775.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	156,775.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	113,520.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,225.7

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 35.1 сая төгрөгийн 3 зөрчил¹ илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

1. ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд иргэдэд олгосон орон сууцны төлбөрийн үлдэгдэл 8.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Зөвлөмж

1. Илрүүлэлт

Хөлөнбуйр сумын 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг 11 зорилтын хүрээнд 85 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12-р сарын 18-ны өдрийн 18/01 дугаар тогтоолоор “хангалтай” гэж дүгнэсэн нь бодитой биш байна.

Үнэлгээнээс түүвэрлэн үзэхэд ОНХС-ийн 13.0 сая төгрөгийн 1 ажил, төсөл, хөтөлбөр арга хэмжээнээс 2 ажил хийгдээгүй байхад тус ажлыг “хангалттай” гэж үнэлсэн байгаа нь үнэлгээг бодитой хийгээгүй байна.

Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өгсөн зөвлөмж

Сумын хөгжлийн төлөвлөгөөг үнэн бодитой үнэлж дүгнэх.

2. Илрүүлэлт

Тайлант онд малын татварын төлөвлөгөөг 65.0 сая төгрөгөөр тооцож төлөвлөснийг өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тооцоход тухайн оны малын тоо толгойн татварыг 22.1 сая төгрөгөөр дутуу тооцож төлөвлөсөн байна.

зөвлөмж

Малын татварын орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж батлуулах.

3. Илрүүлэлт

ОНХС-гийн 13.0 сая төгрөгийн "Мал угааврын ванн засвар"-ын 1 ажил хэрэгжээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

зөвлөмж

Төлөвлөсөн ОНХС-гийн хөрөнгө оруулалтын ажлыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

4. Илрүүлэлт

ХХС-ын хугацаа хэтэрсэн 7 иргэний 25.2 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага байгаас 4 иргэний 19.0 сая төгрөгийн авлага нь ШША-нд шилжсэн, 3 иргэний 6.2 сая төгрөгийн авлага нь 2023 онд төлөх хугацаа дууссан авлага байна.

зөвлөмж

ХХС-гийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулах.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хөлөнбуйр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” заалтыг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөг бодитой үнэлээгүй	1	0					1	0				
Малын татварын төлөвлөгөөг бодитой тооцож төлөвлөөгүй	1	22.1					1	22.1				
ОНХС-гийн 1 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй	1	13.0					1	13.0				
ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд иргэдэд олгосон орон сууцны төлбөрийн үлдэгдэл 8.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй	1	8.6			1	8.6						
3 иргэний 6.2 сая төгрөгийн авлага нь 2023 онд төлөх хугацаа дууссан авлага байна.	1	6.2					1	6.2				
Дүн	5	49.9			1	8.6	4	41.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ	1	-					1	-
Дүн	1	-					1	-

Хөлөнбуйр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 88-ХАА-2024/13/НА-СТА-ТТЗ.
А1170308

Чойбалсан хот

Г Зөрчил арилгуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөлөнбуйр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр баригдаж, иргэдэд олгосон орон сууцны төлбөрийн үлдэгдэл 8.6 сая төгрөгийн он дамжсан авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Он дамжсан авлагыг бүрэн барагдуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөлөнбуйр сумын Засаг дарга Д.Төрбат, Санхүү албаны дарга Б.Болормаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АУДИТОР

Б.ОДХҮҮ



011041268